

Ичинхорлоогийн Цэрэн[✉]¹Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музей,
Монгол улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум**Задгайн урд хүрэнгийн Хүннүгийн хадны зураг**

Хураангуй: Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Задгайн урд хүрэнгийн хадны зургийн дурсгалыг 2025 онд шинээр илрүүлэн бүртгэн баримтжуулсан бөгөөд энэхүү өгүүлэлд тус дурсгалт газрын зарим онцлог дүрслэлийн талаар өгүүлэх болно. Эдгээр дүрслэлийг бусад хадны зураг болон археологийн олдвор хэрэглэгдэхүүн, өмнөх судлаачдын судалгааны үр дүнтэй харьцуулан шинжилсний үндсэн дээр нийтийн тооллын өмнөх III–I зуун буюу Хүннүгийн үед хамааруулах санал дэвшүүлэв. Судалгаанд лууны дүрслэл, сэрээтэй онги тамга, амьтны загварт урлагийн нэгэн онцлог хэв шинж бүхий адуу болон ан агнуурын өгүүлэмжит зургуудыг онцлон авч үзэв. Эдгээр дүрслэлийн хэлбэр, хийц, бэлгэдэл нь Хүннүгийн үед холбогдох эд өлгийн зүйлс болон бусад бүс нутгаас илэрч судлагдсан хадны зурагтай ижилсэж буй нь тухайн дурсгалыг Хүннүгийн соёлын хүрээнд хамааруулах үндэслэл болж байна. Задгайн урд хүрэнгийн хадны зургийн дурсгалт газрын эдгээр зураг дүрслэл нь Монгол орны говийн бүс нутаг дахь Хүннүгийн соёлын ул мөр, хадны зургийн тархалт, дүрслэх хэв маягийн судалгаанд шинэ хэрэглэгдэхүүн болон нэмэгдэж буй ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: *Хүннүгийн хадны зураг, Хүннү тамга, Хүннүгийн амьтны загварт урлаг, луу*

Tseren Ichinkhorloo[✉]¹Bayankhongor Museum, Bayankhongor Province, Mongolia**Petroglyphs of the Xiongnu Period at Zadgayn Urd Khüren**

Abstract: The present study examines selected distinctive motifs from the rock art site of Zadgayn Urd Khüren, located in Shinejinst sum of Bayankhongor Province, Mongolia. Through comparative analysis with rock art and archaeological artifacts, these representations are tentatively attributed to the Xiongnu period (3rd–1st centuries BCE). The study focuses on depictions of a dragon, a seree-integrated ongi tamga (a composite form of a clan emblem), and narrative hunting scenes featuring horses rendered in the Animal-Style Art. The formal characteristics, stylistic features, and symbolic meanings of these images show close parallels with artifacts recovered from elite Xiongnu burials, as well as with rock art from other regions. These correspondences provide a basis for assigning the Zadgayn Urd Khüren rock art to the cultural context of the Xiongnu.

Keywords: *Petroglyphs of the Xiongnu, Xiongnu tamga, Xiongnu Animal-Style Art, dragon*

Удиртгал

Нүүдэлчдийн хамгийн эртний төрт улс Хүннүгийн эзэнт гүрэн нийтийн тооллын өмнөх III-I зуунд өнөөгийн Монгол нутгаар төвлөрөн оршин тогтнож арвин баялаг түүхэн дурсгал үлдээсний дотор хадны зураг зүй ёсоор багтана. Монгол ба хөрш орнуудын нутагт хийсэн судалгаанаас үзэхэд Хүннүгийн хадны зураг өнгөрсөн зууны хоёрдугаар хагасаас эхлэн судалгааны эргэлтэд орсон хэдий ч өнөө хэр илэрч мэдэгдсэн нь тун цөөн тоотой байна. Үүний нэг шалтгаан нь хадны зургийн он цаг тогтоох, түүний дотроос Хүннүгийн үеийн зургийг ялган тодорхойлоход бэрх байдгаас үүджээ. Харин булш, хотын туурь зэрэг он цагийг тогтоох боломж давуутай дурсгалаас илэрсэн эд өлгийн зүйлс дээрх зураг, хээ чимэг, тамга тэмдэг зэрэг дүрслэл хадны зургийн он цагийг тогтоох бололцоог ямар нэг хэмжээгээр бүрдүүлдэг билээ.

Бидний танилцуулах хадны зургууд нь бусад төрлийн археологийн дурсгалтай харьцуулан шинжилж болохуйц бөгөөд тухайн бүс нутгаас илэрч буй Хүннүгийн үед хамаарч болзошгүй хадны зургийн хоёр дахь нь болж байна. Задгайн урд хүрэнгийн дурсгалт газраас Зүүн урагш 60 км зайд Шинэжинст сумын Эрдэнэшанд багийн нутагт орших Өвөр хадны Сонгинотын хадны зургийг археологич Д.Цэвээндорж, Я.Цэрэндагва нар анхлан судалж тодорхойлолт, гар зургийн хамт 2005 онд нийтлүүлжээ (Цэвээндорж, Цэрэндагва 2005, 17-27). Хожим доктор Н.Батболд уг зургийн адуу тууж яваа болон, чоно хөөж яваа морьтой хүмүүсийн дүрслэлийг Хүннүгийн үед хамаарна хэмээн үзсэн буй (Батболд 2011, 27). Ингэхдээ дүрслэлийн онцлог хийгээд төмөр зэвсгийн түрүү үеийн хэв шинжтэй зургийн дээр давхарлан зурсан зэрэг үндэслэлийг дэвшүүлжээ. Бид энэ удаад Задгайн урд хүрэнгийн хадны зураг дахь зарим дүрслэлүүдийг археологийн хэрэглэгдэхүүнтэй харьцуулан шинжилж, тэдгээрийн он цаг, соёлын хамаарлыг тодруулахыг зорив.

Судалгааны арга зүй

Энэхүү өгүүлэлд Задгайн урд хүрэнгийн хадны зургийн дурсгалын зарим онцлог дүрслэлийг шинжлэхдээ чанарын судалгааны арга зүйд тулгуурлав. Юуны өмнө, хээрийн судалгааны ажлын хүрээнд дурсгалт газрын байршил, байгалийн нөхцөл, хадны гадаргуугийн бүтэц, дүрслэлийн тархалт, зохион байгуулалтыг ажиглан, гэрэл зураг, хэмжилт, тэмдэглэлээр баримтжуулсан. Дүрслэл бүрийн байршил, чиглэл, харьцангуй хэмжээ, давхарлал (superimposition)-ыг тэмдэглэн авч, тэдгээрийн харилцан хамаарлыг тогтоохыг зорив. Дараагийн шатанд дүрслэлүүдийг иконографийн үүднээс,

амьтан, хүн, тамга, луу зэрэг дүрсийн хэлбэр, хийц, хөдөлгөөний илэрхийлэл, загварчлал, бэлгэдлийн шинжийг тодорхойлохыг оролдов. Мөн харьцуулсан судалгааны аргын хүрээнд уг дурсгал дахь дүрслэлүүдийг Хүннүгийн үеийн археологийн малтлагаас илэрсэн эд өлгийн зүйлс, ялангуяа язгууртны булшнаас илэрсэн олдворуудтай хэлбэр, хийц, бэлгэдлийн хувьд харьцуулан шинжилсэн. Үүнээс гадна Монгол болон хөрш бүс нутгийн хадны зурагтай адил төстэй болон ялгаатай шинжүүдийг харгалзан үзэж, соёлын хамаарал, тархалтын асуудлыг тодруулахыг зорьсон болно. Түүнчлэн судалгааны үр дүнг өмнөх судалгааны бүтээлүүдтэй харьцуулж, дүрслэлүүдийн он цаг, соёлын хамаарлыг авч үзэв.

Хадны зураг нь он цагийг шууд тогтооход хүндрэлтэй байдаг онцлогтой боловч хад чулууны бат бөх шинж чанарын ачаар дүрслэлийн хэлбэр, хийц урт хугацаанд хадгалагддаг тул харьцуулсан шинжилгээ, хэв шинжийн ижил төстэй байдалд тулгуурлан он цаг, соёлын хамаарлын тухай санал дэвшүүлэв.

Дурсгалт газрын тодорхойлолт

Задгайн урд хүрэнгийн хадны зургийн дурсгалт газар нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын төвөөс зүүн зүгт 2.5 км зайд Эхэн хавцгайт багийн нутагт оршино. Хадны зурагтай хүрэн хадат уулын ар хормойд задгай ус байх бөгөөд үүнийг бодолцон Задгайн урд хүрэн хэмээн онцолж нэрлэжээ. Говь нутагт нуур цөөрөм, гол ус цөөтэйн онцлог хийгээд эртнээс ус булгийг эрхэмлэн үздэг уламжлалын учирт усны ойр орчим, ялангуяа харууцтай өндөрлөг газарт хадны зургийн дурсгал байх магадлал илүүтэй буй.


Задгайн урд хүрэнгийн газрын байцыг үзвэл мал, ан амьтан усанд орохыг ажиг ашигтай байрлалтайн дээр эртнээс эрлийн хүмүүс хийгээд, анчид олон давтамжтай гарах, гарахдаа тогтож удах магадлалтай байсан мэт. Ийм газар орны онцлог нь эзэмшлийг тэмдэглэдэг тамга болон ан гөрөө, мал аж ахуй ба шүтлэг бишрэл, уран сайхны олон шинжийг агуулсан дурсгал үлдэх нөхцөл бүрдүүлсэн байна. Тэнд олон үеийн турш нэмж баяжуулан бүтээсэн зургууд нэг дор буй. Үүнээс энэ удаад зөвхөн Хүннүгийн үед хамаарах боломжтой зургуудыг онцлон авч үзэхийг зорив.

Судалгааны үр дүн

1. Луу: Задгайн урд хүрэнгийн хадны зургийн дурсгалт газарт бусад зургаасаа сондгой байршилд лууны уран тод зураг байна. Хадны зургууд гол төлөв уул хадны өвөр талд энгэр ээвэр хэсгээр байрладаг атал уг зураг ар газарт буйгаараа онцлогтой. Уулын ар биед хойд зүг рүү



Зураг 1. 1-Задгайн урд хүрэнгийн лууны зураг, 2- Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Гол модны Хүннүгийн язгууртны булинаас гарсан мөнгөн луу (Чингис хаан Үндэсний музейн сан хөмрөг), 3-Лууны дүрт хүрэл арал (Түүвэр олдвор) (Эрэгзэн 2011:131), 4-Лууны дүрт хүрэл аралны хэсэг, Өвөрхангай аймгийн Өлзийт сум Борзонгийн 5-р були (Эрэгзэн 2011:130).



Зураг 2. 1-Задгайн урд хүрэнгийн сэрээтэй онги тамга, 2- Говь-Алтай аймгийн Халиун сумын Цагаан голын тамга (Доржсүрэн 1963, 25), 3- Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт орших Тэрэлжийн дөрвөлжин хэмээх Хүннүгийн хотын малтлагаас илэрсэн нүүр вааран дээр хэвлэсэн тамга (Эрдэнэболд 2008, 355), 4- Ховд аймгийн Үенч сумын Ямаан усны хаданд сийлсэн тамга (Төрбат нар 2012, 160), 5- Төв аймгийн Борнуур сумын Хараагийн Ноён уулын Сүжигтийн аманд хийсэн малтлага судалгааны явцад 31-р булинаас гарсан аяган дээрх тамга (Төрбат нар 2012, 158).

харсан тогтоцтой ургаа хадны налуу гадаргууд лууг баруун зүгт хандуулан бүх талбайгаар хонхойлгон 15х8см хэмжээтэй сийлжээ. Хадны өнгөн хэсгийг товойлгон үлдээх аргаар нүдийг нь гаргасан ба дөрвөн хөлтэй урд мөчиндөө гурван хумстайгаар зуржээ. Цээжнээс урагших хэсэг нь жигд хонхойлсон сийлбэртэй бол хойд хэсэг нь жигд биш цоолборлосон байна. Өнгө нь цайвар шаргал ба тус газарт буй хүрэн бор өнгөтэй зургуудаас нэлээд хожуу зурсан болох нь илэрхий.

2. Тамга: Бидний олж үзсэнээр Задгайн урд хүрэнгийн хадны зурагт хоёр төрлийн тамга дүрсэлсэн байх бөгөөд тэдгээрийн нэг нь Хүннүгийн үед, нөгөө нь Уйгурын үед хамаарах бололтой. Хүннүгийн үед хамааруулан үзэж буй тамга бол сэрээтэй онги тамга бөгөөд Хүннүгийн олон тамганы үндсэн бүрэлдэхүүн болох онги, сэрээ тамганы нийлэмжээс бүтжээ. Дээш харсан байрлалтай жижгэвтэр хавтгай чулууны толигор гадаргууд голлуулан 10х5 см хэмжээтэй өнгөцхөн цохиж сийлсэн байна. Тамганы дээд талд янгир барьсан чоныг зүүн гар тийш хандуулан п үсэг мэт хэлбэртэй, урт нарийн сүүл нь гогцоорон эргэсэн байдалтай сийлсэн бөгөөд өнгө болон сийлсэн арга барилаараа тамгатай нэгэн адил байна.

3. Чоно намнаж буй морьтон: Хавтгай чулууны тэгш гадаргууд нэгэн морьтон чоно намнаж буй өгүүлэмжтэй зургийг баруун гар тийш харуулан бүх талбайгаар хонхойлгон цохих аргаар сийлжээ. Энэ зурагт морийг загварчлан дүрсэлсэн хэв маяг нь тун өвөрмөц юм. Морины цээж ба гуя хондлойн хэсгийг өргөн, хүзүү болон гэдэс хээлээр нарийсган дүрсэлсэн нь уран донжтой. Сүүл нь арагш мурилзан хийссэн, бэлгэт гөрөөсний эвэр мэт долгиотсон өндөр хөхөл дэлтэй байна.

Хүнийг нэг шулуун зураасаар тун чадмаг гаргасан бөгөөд толгой, нум татсан гарын тохойг бага зэрэг товойлгоод, хөлийг нь ээтэн хоншоортой гуталтай мэт гэдрэг эргүүлэн сийлжээ. Морины ташаа ба хүний шилбийг холбосон нэгэн ташуу зураас татаж ямар нэгэн уяаг дүрсэлсэн байх бөгөөд моринд мордоход хэрэглэдэг дөрөөвч, эсвэл дээсэн дөрөөг зааж байгаа бололтой. Морьтой хүний урд талд гурав, ар талд нэг бүгд дөрвөн ижил амьтныг зурсан байгааг бид чоно хэмээн үзэв. Дүрслэлийн хэв шинжийн хувьд ялангуяа морьтой хүний ард яваа чоныг хөтөлгөө морь цахлан зогсох мэт ижил төстэй зурсан байна. Гэвч биеийн харьцаанаас харахад чоно болох нь мэдэгдэнэ. Морины гуянаас хойш хөндлөн шугамаар илэрхийлсэн зүйл нь цулбуур бус чоныг өшиглөж буй хойд хөл бөгөөд ард нь яваа чоно арагш гэдийн далдирч буйг илэрхийлжээ. Морьтой хүний урд талд харайж яваа чоныг урт хөлтэй, нарийн жавхгар дүрсэлжээ.

4. Чоно хөөж яваа морьтон ба бусад дүрслэл.


Бидний онцлон өгүүлж буй бэлгэт гөрөөсний эвэр мэт өндөр хөхөл дэлтэй, жавхгар гэдэстэй морьтой ижил хэв шинжтэй зураг тус дурсгалт газарт дахин 4 удаа тохиолдож байна.

Үүний нэг нь чоно хөөж яваа морьтой хүний зураг юм. Налуу байрлалтай, тэгш нүүртэй чулуун дээр голлуулан дүрсэлсэн уг зурагт морины чихийг тодорхой гаргаснаараа бусдаасаа онцлог болно. Хүнийг бодит байдлаар зурж, ганзагандaa ямар нэгэн зэвсэг авч явааг харуулсан байна.

Мөн өөр нэгэн том чулуунаа хүрлийн үеийн мөөгөн хэлбэрийн дуулгатай хүмүүс ан хийж буй зохиомжтой зургийн чөлөөнд давхарлан нэг адуу, нэг морьтой хүнийг зурсан байна. Адууны



Зураг 3. 1-Чоно намнаж буй морьтон, Баянхонгор аймгийн Шинэжинст сум Задгайн урд хүрэн.
2-Бэлгэт гөрөөсний эвэр мэт хөхөл дэлтэй, жавхгар гэдэстэй адууны зураг, Говь-Алтай аймгийн
Халиун сум Цагаан голын хадны зураг (Зургийн эх сурвалж: <https://mongoltoli.mn/history/h/673>)



Зураг 4. Задгайн урд хүрэнгийн хадны зургууд: 1-Тамгатай хамт дүрсэлсэн янгир барьсан чоно, 2-Хүрэл зэвсгийн үеийн зураг дээр нэмж зурсан адуу ба морьтой хүний зураг, 3-Морьтой хүн, 4-Адуу, бэлгэт гөрөөс

дүрслэлийн хэв шинж нь өмнөх зургуудтай нэг адил болно.

Үлдсэн нэг адууны зургийг наран ургах зүгт харсан тэгш толигор хадны гадаргууд зүүн гар тийш хандуулан, ур хийцийн талаар арай дулимагхан боловч ижил загвараар сийлжээ. Уг адууны ар талд биеэр арай бага толгойдоо урт ганц эвэртэй богино годгор сүүлтэй нэгэн амьтныг мөн л зүүн гар тийш хандуулан дүрсэлсэн нь бэлгэт гөрөөс мэт харагдана.

Хэлэлцүүлэг

Лууны дүрслэлийн тухайд. Дүрслэлийн хэв маяг ялангуяа хүзүү, толгойн загвар нь Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг Гол модны Хүннүгийн язгууртны булшнаас илэрсэн хос мөнгөн луутай нэлээд төстэй байна. Ялангуяа нумарсан өндөр хүзүү, эвэр, гэдрэг эргэсэн хоншоор, амаа ангайсан байдал зэрэг хэлбэр дүрсийн онцлог, дөрвөн хөлт араатны хэв шинжээрээ ижилсэж байна. Гол модноос олдсон мөнгөн луу нь Хүннүгийн амьтны загварт урлагийн хүрээнд дүр дүрслэл, ур хийцийн хувьд онцгой байр суурь эзэлдэг. Үүнтэй ижилсэх дүрслэл хадны зургийн дурсгалаас илэрч буй

нь уг дүрслэлүүдийг нэгэн цаг үед уран сайхны сэтгэлгээ, соёлын нийтлэг хэв маягийн хүрээнд бүтээсэн байх боломжтойг илтгэнэ. Хүннүгийн дүрслэх урлагт домгийн амьтан болох лууны дүр бидний өгүүлэн буй хадны зурагтай ижил төстэй хэв шинжээр уламжлагдаж байсныг илтгэх өөр бусад биет олдвор нь лууны дүрстэй бүсний аралнууд болно. Өвөрхангай аймгийн Өлзийт сумын Борзонгийн 5-р булшнаас олдсон лууны дүрст хүрэл аралны хэсэгт нүд, хүзүү, хошуу, хоншоорын хэв маяг нь адил төстэй байна. Түүвэр байдлаар олдсон өөр нэгэн бүсний аралд лууг мөн л дөрвөн хөлтэй нумарсан хотгор хүзүүтэй, гэдрэг эргэсэн хоншоортойгоор дүрсэлсэн байна. Энэ нь хадны зураг ба археологийн биет олдворын дүрслэл хоорондын он цаг ба соёлын хамаарлыг харуулж байна. Судлаачдын Хүннүгийн үед холбогдоно хэмээн үзсэн хадны зургийн дотор урьд өмнө лууны дүрс мөн тохиолдож байжээ. Сүхбаатар аймгийн Дэлгэрхаан уулын Цагаан элэгийн хадны зургийг Хүннүгийн үеийнх хэмээн үздэг (Батсайхан нар, 1998). Цагаан элэгийн хадны зураг дахь лууны дүрслэл нь зураасан зургийн аргаар зурагдсан байна. Харин Задгайн урд хүрэнгийн лууны зураг нь илүү бодит дүрслэлтэй

бөгөөд археологийн олдвортой харьцуулан үзэж болохуйц тодорхой байгаагаараа онцлогтой.

Тамганы дүрслэлийн тухайд. Тамганы зураг өнгөний хувьд лууны зургаас арай илүү гандмал бор шаргал байна. Үүнээс үзэхэд бүтээсэн он цагийн хувьд арай түрүү үед хамаарах бололтой. Гэвч тус газрын чулуулгийн онцлогоос шалтгаалж нэг зурагт цайвар шаргал, бор шаргал өнгө ууссан байгааг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь чулууны өнгө болон сийлбэрийн гүний ялгаа зэргээс шалтгаалж байна. Цаашдын судалгаанд үүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Хүннүгийн археологийн дурсгалуудаас илэрч олдсон тамга дотроос үүнтэй яг ижил тамга Говь-Алтай аймгийн Халиун сумын Цагаан голын хадны зурагт буйг ахмад археологич Ц.Доржсүрэн 1963 онд гар зураг үйлдэн нийтлүүлсэн бөгөөд он цагийг нь Түрэгийн үед хамааруулжээ (Доржсүрэн 1963, 25). Үүнийг хожмын судлаачид Хүннүгийн үеийнх хэмээн тодорхойлсон бөгөөд бусад хадны зургуудтай харьцуулан үзжээ (Төрбат нар 2012, 137). Ийм сэрээтэй онги тамгыг гол болгон нэмэлт дүрсээр баяжуулсан тамга урьд өмнө цөөнгүй илэрч судлагдсан байна. Тухайлбал: Ховд аймгийн Үенч сумын Ямаан усны хадны зурагт буй сүйх тэргээр зорчин яваа болон морьтой хүмүүсийн дүрслэлийн дэргэд ийм төрлийн тамга сийлээтэй байдаг (Төрбат нар 2012, 160). Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт орших Тэрэлжийн дөрвөлжин хэмээх Хүннүгийн хотын малтлагаас илэрсэн нүүр вааран дээр хэвлээтэй тамгануудын дунд ижил төстэй тамга буй (Эрдэнэболд 2008, 355). Төв аймгийн Борнуур сумын Хараагийн Ноён уулын Сүжигтийн аманд хийсэн малтлага судалгааны явцад 31-р булшнаас гарсан чий будагтай аяган дээрх зузай тамганы дүрслэлийг нэмж үүсгэсэн сэрээтэй онги тамга зэргийг дурдаж болно (Төрбат нар 2011, 159).

Ийм төрлийн тамганууд их төлөв Хүннүгийн язгууртнуудад хамаарах дурсгалаас илэрч олдсон байх ажээ. Үүнээс тамгыг эзэмшигч, бүтээгчийн талаар өгүүлэх сэжүүр ургах бөгөөд судлаачид үүнийг анхааран үзэж зохих дүгнэлтийг гаргасан байна. Археологич Ц.Төрбат, Д.Батсүх, Н. Баярхүү нар монгол нутгаас болон хөрш зэргэлдээ Төв азийн бүс нутгаас илэрч судлагдсан энэ төрлийн тамгануудыг харьцуулан судалж, өмнөх судалгааны үр дүнг цэгнэн үзээд Хүннүгийн ноёлох овог болох Люаньди овгийн тамга байх бүрэн боломжтой хэмээн дүгнэсэн байна (Төрбат нар 2011, 151).

Бидний илрүүлэн олсон тамга Хүннүгийн язгууртны булшнаас гарсан мөнгөн луутай адил төст лууны сийлмэл зурагтай нэг газраас илэрсэн, Хүннүгийн хот болон язгууртны булшны малтлагаас гарсан эд өлгийн зүйлс дээрх тамгатай

ижил төстэй тул мөн л Хүннүгийн ихэс дээдэст хамаарах бололтой. Уг тамганы үндсэн дүрс нь онги эсвэл уруугаа харсан сэрээ тамганы аль нэг нь болох бөгөөд үндсэн дүрс дээр нөгөөг нь нэмж гаргасан хувилбар тамга болно. Онги бол Хүннүгийн дийлэнх тамганы үндсэн дүрс боловч сэрээ тамга ч мөн зарим тамганы үндсэн дүрс болсон хувилбар буйг анхаарах хэрэгтэй.

Дүрсний утга бэлгэдлийг анхааран үзвэл онги тамга нарны бэлгэдэлтэй харин сэрээ тамганы бэлгэдлийн утга одоогоор бүрэн тодорхойлогдоогүй байна. Үүнийг тодруулахад хадны зураг дахь тамганы зохион байгуулалтыг чухалчлан анзаарах хэрэгтэй. Учир нь зарим эд өлгийн зүйлс дээрх тамганы аль тал нь дээш харахыг шууд онооход бэрхшээлтэй тал бий. Харин хадны зурагт бол ийм эргэлзэх зүйл үгүй юм. Хоёр хөлтэй сэрээ тамгыг хадны зурагт голдуу задгай тал нь доош, битүү тал нь дээш харснаар дүрсэлсэн байдаг. Уг тамганы хэлбэр дүрс ба задгай талаараа доош харж дүрслэгддэг онцлогийг харгалзан үзвэл уултай төстэй байна. Чингэвэл бидний өгүүлэн буй сэрээтэй онги тамга нь уул [газар эхийн] ба нар [дээд тэнгэрийн] гэсэн хоршлыг агуулсан бэлгэдэлт дүрс бөгөөд газрыг дээдэлж, тэнгэрийг шүтэх ёсны илрэл байж болох юм. Мөн эдгээр тамганы нийлэмж нь хүний дүрстэй болдог нь сонирхолтой бөгөөд хүмүүн тэнгэр газар гурвыг нэгэн дүрсэнд хураан багтаасан мэт. Мөн тамгатай хамт зураатай буй чононд бариулсан янгирыг дүрслэхдээ гэдрэг нь харуулан толгойг нь уруугаа унжуулан зурсан байна. Энэ нь амь алдсан буюу нөгөө ертөнц рүү одсон гэсэн утга санааг илэрхийлсэн бэлгэдэл бололтой. Уг зургийн жишээгээр бол Хүннү ба скифийн амьтны загварт урлагт амьтны биеийг таллан дээш доош эргүүлэн дүрсэлдэг нь амьдрал ба нөгөө ертөнцийг холбож байгааг илэрхийлсэн бэлгэдэл хэмээн ойлгогдож байна.

Тамганы хэрэглээний хувьд ижил төрлийн тамганы олон хувилбарыг хэрхэн ойлгох тухайд эрдэмтэн Х.Пэрлээгийн өрхийн шинэ тамга үүсгэх ёсны тухай угсаатны зүйн жишээгээр тайлбарласан судалгаа бэлээхэн хариулсан буй (Пэрлээ 1975, 50)¹. Түүнчлэн Их монгол улсын үеийн тамгыг судалж, алтан ургийнхны тамганы соёлыг тодорхойлсон Б.Нямаагийн *овгийн тамга*

¹ “Өрхийн малын шинэ тамга үүсгэхдээ 1/ хуучин их өрхийн тамганы дүрс дээр шинэ зураас нэмэх, 2/ хуучин нэг тамганы дүрсийг хоёр гурав давтан дүрслэх, 3/ хуучин хоёр тамгыг нэгтгэх, 4/ нэгэн тамгыг малын зөв буруу талд давтан дарах, 5/ хуучин тамганы дүрсэнд номын үсэг, тооны үсэг нэмэх зэргээр олон янз аргыг хэрэглэдэг учраас яг ижил тамга тэмдэгтэй мал тохиолдох нь (тэр тодорхой нутагтаа) бараг үгүй байжээ”.

залгамжилсан хүн түрүү үеийнхээ тамгыг тэр хэвээр нь авдаггүй, харин уг тамганы үндсэн шинжийг хадгалсан дүрс оролцуулсан шинэ тамга үүсгэж өөрийн угсааны тамга болгож байсан бололтой (Нямаа 2005, 36) хэмээсэн тайлбар байдаг. Нэмж дурдахад малын имний жишээгээр ч мөн ийм ёс бий бөгөөд зөв буруу чихэнд зөрүүлэн хийх ба нэмж өөрчлөн өөрийн өмчийг тэмдэглэдэг билээ. Мөн голомтоо залган үлдсэн хүн эцэг эхийн им тамгыг тэр хэвээр нь залган авах нь ч бий. Үүнээс үзэхэд сэрээтэй онги тамга ийм зарчмаар үүсэн нэмж баяжин хэрэглэгдэж байжээ. Сэрээтэй онги тамга Хүннүгийн олон тамганы үндсэн махбод болох бөгөөд энэ нь уг тамганы үүсэл нь бусад үүсгэмэл тамганаасаа эрт үед холбогдохыг илэрхийлж байна. Задгайн урд хүрэнгийн сэрээтэй онги тамга нь чулууны өгөршлийн байдлаараа зарим зургаасаа арай эрт үед зурагдсан мэт байгаа нь үүнээс үүдсэн бололтой.

Амьтан ба хүнийг дүрсэлсэн хэв маягийн тухайд. Задгайн урд хүрэнгийн хадны зураг дахь зарим амьтан ба хүнийг загварчлан дүрсэлсэн хэв маяг нь хадны зурагт тэр бүр тохиолдохгүй онцлогтой байна. Хүннүгийн хадны зургийн тухай доктор Н.Батболд “Амьтдыг урт нарийн биетэй, шавхнуун буюу тасрах шахам гурайтсан гэдэстэй зурдаг нь Монгол, ОХУ-ын Уулын Алтай, Тувагийн Хүннүгийн үеийн хадны зургийн нийтлэг шинж хэмээн үзэж болно” (Батболд 2011, 28) гэж тодорхойлсон байна. Бидний өгүүлэн буй зураг дээрх морьтой ижил хэв маягтай адууны зураг Говь-Алтай аймгийн Халиун сумын Цагаан голын хадны зурагт Хүннүгийн тамгатай хаданд сийлээтэй байдаг. Тус адууны зургийг судлаачид Хүннүгийн үед хамааруулан үзсэн зүйл үгүй бололтой.

Цагаан голын хадны зурагт буй адууны дүрслэл нь хажуудаа Хүннү тамгатай, бидний илрүүлэн олсон зураг ч мөн дэргэдээ ижил төрлийн тамгатай байгаа нь анхаарууштай зүйл юм. Эдгээр зураг газар зүйн байршлын тухайд хэдэн зуун километрийн алсад орших хэдий ч тус бүртээ ижил төрлийн тамгатай хамт дүрслэгдсэн тул он цаг хийгээд бүтээгчид нь нэгэн адил байх бололцоотой. Иймээс Задгайн урд хүрэнгийн хадны зураг дахь дээрх төрлийн дүрслэлийг Хүннүгийн үед хамааруулан бүс нутгийн хэмжээнд тархсан дүрслэлийн нийтлэг уламжлалын илрэл хэмээн үзэв.

Дээрх зургуудад буй адууг дүрсэлсэн хэв маягийг зөвхөн загварчилсан дүрслэл хэмээн үзэх нь учир дутагдалтай байна. Эдгээр зурагт адууг загварчлан дүрслэхийн зэрэгцээ биеийн онцлог шинж буюу нарийн зэгзгэр хөлтэй, өндөр хүзүүтэй дэл сүүл шингэнтэй цээж өргөн гэдэс хээлээрээ

жавхгар тийм нэгэн зүйлийн адууны онцлогийг ямар нэг хэмжээнд тусгасан байж болох юм.

Товч дүгнэлт

Баянхонгор аймгийн нутгаас шинээр илэрсэн Задгайн урд хүрэнгийн хадны зураг дахь лууны дүрслэл, сэрээтэй онги тамга, амьтны загварт урлагийн нэгэн онцлог хэв шинж бүхий адуу болон ан агнуурын өгүүлэмжит зургууд нь Хүннүгийн үеийн археологийн олдвор хэрэглэгдэхүүнтэй шинж төрх, хэв загварын хувьд ижилхэн байна. Ялангуяа лууны дүрслэл нь

язгууртны булшнаас илэрсэн мөнгөн луутай ижил хэв загвартай байгаа тул он цагийг баримжаалах боломж олгож байна. Мөн тамганы дүрслэл нь өмнөх судлаачдын харьцуулан судалсан Хүннүгийн язгууртны овгийн тамгатай ижил төстэй байна. Иймд уг хадны зургийн дурсгалын энэхүү дүрслэлүүдийг Хүннүгийн үед хамаарна хэмээн үзэв. Задгайн урд хүрэнгийн хадны зургийн дурсгал судалгааны эргэлтэд орсноор Монгол ба бүс нутгийн хадны зургийн судалгаа, ялангуяа Хүннүгийн үеийн хадны зураг, тамга тэмдгийн судалгаанд анхааран үзэх шинэ хэрэглэгдэхүүн нэмж байна. Цаашид тухайн дурсгалыг дахин нягталж, цогц байдлаар шинжлэн үзэх шаардлагатай байна.

Талархал

Хадны зургийн дурсгалыг мэдээлж, газарчлан тусалсан Шинэжинст сумын Засаг даргын тамгын газрын Байгаль хамгаалагч Н.Мөнхдалай болон гэрэл зураг авах, хэмжилт хийх ажлыг хамтран гүйцэтгэсэн Баянхонгор аймгийн музейн Бүртгэл мэдээллийн санч Б.Эрдэнэхуяг, тайлбарлагч Т.Батсүрэн нарт талархал илэрхийлж байна.

НОМ ЗҮЙ

Амгалантөгс, Ц., Амартүвшин, Ч. “Нумын наалтан дээрх сараачмал хэдэн дүрс”. *Археологийн судлал*. Боть XXIII, 88-95. Улаанбаатар, 2005.

Батболд, Н. “Хүннүгийн хадны зураг”. *Археологийн судлал*. Боть XXXI, Дэвтэр 2, 26-39. Улаанбаатар, 2011.

Батсайхан, З. *Хүннү (археологи, угсаатны зүй, түүх)*. Улаанбаатар, 2002.

Батсайхан, З., Эрдэнэбат, У., Төрбат, Ц. “Цагаан элгийн хадны зураг”. *Эрдэм шинжилгээний бичиг. МУИС-ийн Нийгмийн ухааны факультет*. №4 (133), 266-279. Улаанбаатар, 1998.

Доржсүрэн, Ц. *Говь-Алтайн Цагаан голын хадны зургууд*. Улаанбаатар, 1963.

Кубарев, В.Д., Цэвээндорж, Д. Якобсон, Е. *Петроглифы Цагаан салаа и Бага Ойгура (Монгольский Алтай)*. Новосибирск-Улаанбаатар-

Юджин, 2005.

Нямаа, Б. *Монголын эзэнт гүрний зоосон мөнгө ба хаадын овгийн тамга (XIII-XIV зуун)*. Улаанбаатар, 2005.

Новгородова, Э.А. *Мир петроглифов Монголии*. Москва, 1984.

Пэрлээ, Х. *Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь*. Улаанбаатар, 1976.

Сүхбаатар, Г. *Монголчуудын эртний өвөг (Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал МЭӨ IV - МЭ II зуун) Монголын эртний түүх судлал*. Боть I. Улаанбаатар, 1980.

Төрбат, Ц., Батсүх Д., Баярхүү Н. “Хүннүгийн археологийн тамгууд Ляунди овгийн тамга болох нь”: *Археологийн судлал*. Боть XXXII, 136-161. Улаанбаатар, 2012.

Цэвээндорж, Ц. *Монголын эртний урлагийн түүх*. Улаанбаатар, 1999.

Цэвээндорж, Д., Цэрэндагва, Ц. “Баянхонгор аймгийн нутгаас олдсон хадны зургийн зарим дурсгалаас” *Археологийн судлал*. Боть XXIII, 16-31. Улаанбаатар, 2005.

Эгиймаа, Ц. “Хүннүгийн зураасан зураг”: *Археологийн судлал*. Боть XXI, 69-74. Улаанбаатар, 2003.

Эрдэнэболд, Л. “Хүннүгийн хот суурины судалгааны асуудалд”: *Талын их эзэнт гүрэн-Хүннү. Монгол-Солонгосын хамтарсан судалгааны 10 жилийн ойн симпозиум*. Солонгосын үндэсний музей, 355-369. Сөүл, 2008.

Эрдэнэбат, У. “Хахуулын голын хадны зураг” *Археологийн судлал*. Боть XXVI, 32-56. Улаанбаатар, 2008.

Эрэгзэн, Г. *Хүннүгийн өв соёл*. Улаанбаатар, 2011.

REFERENCES

Amgalantugs, Ts., Amartuvshin, Ch. “Numyn naaltan deerkh saraachmal kheden dürs”. *Arkheologiiin sudlal*. Tomus XXIII, 88-95. Ulaanbaatar, 2005.

Batbold, N. “Khünnügiin khadny zurag”. *Arkheologiiin sudlal*. Tomus XXXI, Fasciculus 2, 26-39. Ulaanbaatar, 2011.

Batsaikhan, Z. *Khünnü (arkheologi, ugsaatny züi, tүүikh)*. Ulaanbaatar, 2002.

Batsaikhan, Z., Erdenebat, U., Turbat, Ts. “Tsagaan elegiin khadny zurag”. *Erdem shinjilgeenii bichig. MUIS-iin Niigmiin ukhaany fakultet*. №4 (133), 266-279. Ulaanbaatar, 1998.

Dorjsuren, Ts. *Govi-Altain Tsagaan golyn khadny zurguud*. Ulaanbaatar, 1963.

Kubarev, V.D., Tseveendorj, D., Yakobson, E. *Petroglify Tsagaan Salaa i Baga Oigura (Mongolskii Altai)*. Novosibirsk-Ulaanbaatar-Yudjin, 2005.

Nyamaa, B. *Mongolyn ezent gürnii zooson möngö ba khaadyn ovgiin tamga (XIII-XIV zuun)*. Ulaanbaatar, 2005.

Novgorodova, E.A. *Mir petroglifov Mongolii*. Moskva, 1984.

Perlee, Kh. *Mongol tümnii garlyg tamgaar khaij sudlakh ni*. Ulaanbaatar, 1976.

Sukhbaatar, G. *Mongolchuudyn ertnii övөг (Khünnü naryn aj akhui, niigmiin baiguullal, soyol, ugsaa garval)* Mongolyn ertnii tүүkh sudlal. Tomus I. Ulaanbaatar, 1980.

Turbat, Ts., Batsukh, D., Bayarkhuu, N. “Khünnügiin arkheologiin tamguud Lüandi ovgiin tamga bolokh ni”. *Arkheologiin sudlal*. Tomus XXXII, 136-161. Ulaanbaatar, 2012.

Tseveendorj, Ts. *Mongolyn ertnii urlagiin tүүkh*. Ulaanbaatar, 1999.

Tseveendorj, D., Tserendagva, Ts. “Bayankhongor aimgiin nutgaas oldson khadny zurgiiin zarim dursgalaas”. *Arkheologiin sudlal*. Tomus XXIII, 16-31. Ulaanbaatar, 2005.

Egiimaa, Ts. “Khünnügiin zuraasan zurag”. *Arkheologiin sudlal*. Tomus XXI, 69-74. Ulaanbaatar, 2003.

Erdenebold, L. “Khünnügiin khot suuriny sudalgaany asuudald”. *Talyn ikh ezent guren-Khünnü. Mongol-Solongosyn khamtarsan sudalgaany 10 jiliin oin simpozium*. Solongosyn ündesnii muzei, 355-369. Söül, 2008.

Erdenebat, U. “Khakhuulyn goliin khadny zurag”. *Arkheologiin sudlal*. Tomus XXVI, 32-56. Ulaanbaatar, 2008.

Eregzen, G. *Khünnügiin öv soyol*. Ulaanbaatar, 2011.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>